



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/262

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 17 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант суманд зохион байгуулагдаж байгаа “Сэрүүн сайхан хангай” айзам уртын дууны улсын уралдааныг зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 6,000,000 (зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын тамгын газрын Соёл, урлаг хөтөлбөрийн “Өв хамгаалах арга хэмжээ”-ний зардлаас зарцуулахыг зөвшөөрсүгэй.

2.Батлагдсан хөрөнгийг зохих журмын дагуу төлөвлөсөн үйл ажиллагаанд зарцуулж тайлагнахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), Жаргалант сумын Засаг дарга (Ц.Бямбажав) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ